




Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл 2022 оны эхний хагас жилд 2.0 их наяд төгрөг болж, 1.9 (97.1%) их наяд төгрөгийн ажлыг дотоодын барилгын байгууллага, 56.8 (2.9%) тэрбум төгрөгийн ажлыг гадаадын барилгын байгууллага гүйцэтгэсэн байна.

Барилга угсралт, их засварын ажил 2022 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 224.4 (12.9%) тэрбум төгрөгөөр өсөхөд дотоодын байгууллагын барилгын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 216.6 (12.8%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн.



Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл, гүйцэтгэгчийн төрлөөр, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар



Дотоодын барилгын байгууллагаас хувийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 1.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 402.8 (28.2%) тэрбум төгрөгөөр өслөө. Харин төрийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 54.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 180.8 (77.0%) тэрбум төгрөгөөр, гадаадтай хамтарсан байгууллагынх 16.5 тэрбум төгрөг болж, 5.3 (24.5%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.





Энэ оны эхний хагас жилд барилга угсралт, их засварын ажлын 48.8 хувийг орон сууцны барилга, 35.4 хувийг орон сууцны бус барилга, 12.7 хувийг инженерийн барилга, байгууламж, 3.1 хувийг их засварын ажил эзэлж, өмнөх оны мөн үеэс орон сууцны барилгын ажлын эзлэх хувь 9.7 нэгж хувиар, их засварын ажил 0.9 нэгж хувиар өссөн бол инженерийн барилга, байгууламжийнх 10.4 нэгж хувиар, орон сууцны бус барилгынх 0.2 нэгж хувиар тус тус буурсан байна.




Барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажлын хэмжээ, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, төрлөөр, тэрбум төгрөг

БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН БҮТЭЦ /ХУВИАР/






Орон сууцны бус барилга, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, төрлөөр



Орон сууцны бус барилгын ажил 2022 оны эхний хагас жилд 694.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 76.8 (12.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнд үйлдвэрийн барилгын ажил 37.9 (11.3%) тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч сургууль соёлын барилгын ажил 31.2 (25.8%) тэрбум төгрөгөөр, худалдаа, үйлчилгээний барилгын ажил 27.0 (48.1%) тэрбум төгрөгөөр, бусад орон сууцны бус барилгынх 53.3 (64.8%) тэрбум төгрөгөөр, эмнэлгийн барилгынх 3.2 (13.5%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажлын хэмжээ, тэрбум төгрөгөөр



Улаанбаатар хотод 2022 оны эхний хагас жилд 1.1 их наяд төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийгдсэн нь улсын дүнд 56.5 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 8.6 нэгж хувиар өссөн байна. Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 2022 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр Өмнөговь аймагт 348.5 тэрбум төгрөг, Орхон аймагт 83.2 тэрбум төгрөг болж, энэ нь аймгуудын барилга угсралтын ажлын дүнд 52.2 хувийг эзэлж байна.